



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Нэр дэвшигчдэд тавигдах болзол шалгуур,  
түвшин тогтоох журмын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дугаар хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4, 15.5, 16 дугаар зүйлийн 16.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад төрийн бусад байгууллагаас томилогдон ажиллахаар нэр дэвшигчдэд тавигдах болзол шалгуурыг нэгдүгээр хавсралтаар, нэр дэвшигчдийн дипломат албаны ерөнхий болон гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоох журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Болдбаатар/-д даалгасугай.

САЙД



Л.ПҮРЭВСҮРЭН


Гадаад хэргийн сайдын 2015 оны 11 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



**ХИЛИЙН ЧАНАДАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДАД  
ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГААС ТОМИЛОГДОН АЖИЛЛАХААР НЭР  
ДЭВШИГЧДЭД ТАВИГДАХ БОЛЗОЛ ШАЛГУУР**

1. Дээд боловсролтой байх;
2. Төрийн албанд 5-аас доошгүй жил, үүнээс тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх;
3. Олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төрийн харилцааны талаар зохих мэдлэгтэй байх /тусгай журмын дагуу түвшинг тогтооно/;
4. Түгээмэл хэрэглэгддэг гадаад хэл, эсхүл тухайн томилогдон ажиллах улсын албан ёсны хэлийг албан ажил явуулах шаардлагын түвшинд эзэмшсэн байх /тусгай журмын дагуу түвшинг тогтооно/;
5. Монгол хэл дээр бичиг баримт боловсруулах чадвартай байх;
6. Эрүүл мэндийн хувьд төрийн тусгай алба хаах шаардлагыг бүрэн хангасан байх(Магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын тодорхойлолт);
7. Ёс зүйн зөрчил дутагдал гаргаж байгаагүй байх (Ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт);
8. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй (Цагдаагийн байгууллагын тодорхойлолт);
9. Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх,

---oOo---



**ХИЛИЙН ЧАНАДАД СУУГАА ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДАД  
ТӨРИЙН БУСАД БАЙГУУЛЛАГААС ТОМИЛОГДОН АЖИЛЛАХААР НЭР  
ДЭВШИГЧДИЙН ДИПЛОМАТ АЛБАНЫ ЕРӨНХИЙ БОЛОН ГАДААД  
ХЭЛНИЙ МЭДЛЭГИЙН ТҮВШИНГ ТОГТООХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад Гадаад хэргийн яамнаас бусад төрийн байгууллагаас томилогдон ажиллахаар нэр дэвшигчдийн дипломат албаны ерөнхий болон гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох үйл ажиллагааг явуулахад энэхүү журмыг мөрдөнө..

1.2.Түвшин тогтоох үйл ажиллагааны зорилго нь дипломат албаны төрийн тусгай албан тушаалын болзол шалгуурыг болон тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад томилон ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.3.Дипломат албаны ерөнхий мэдлэг гэдэгт олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төрийн харилцааны талаар зохих түвшний мэдлэгтэй байх, гадаад хэл гэдэгт түгээмэл хэрэглэгддэг нэг гадаад хэл, эсхүл тухайн томилогдон ажиллах улсын албан ёсны хэлийг албан ажил явуулах шаардлагын түвшинд эзэмшсэн байхыг ойлгоно.

1.4.Түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдах нэр дэвшигч нь энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан болзол шалгуурын 3, 4-т зааснаас бусдыг хангасан байна.

1.5.Нэр дэвшигчийг Гадаад хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газраас холбогдох мэдээллээр хангана.

1.6.Дипломат албанд элсэн орох шалгалт өгч тэнцэн дипломат ажилтны тангараг өргөсөн бөгөөд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу өөр төрийн байгууллагад шилжсэн, эсвэл харилцан тохиролцсоны үндсэн дээр төрийн бусад байгууллагад сэлгэн ажиллаж байгаад ДТГ-т томилогдохоор нэр дэвшигчид нь энэ журмаар тогтоосон дипломат албаны ерөнхий болон гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдахгүй.

**Хоёр. Түвшин тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах**

2.1.Түвшин тогтоох үйл ажиллагааг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан 5-6 хүний бүрэлдэхүүнтэй комисс хариуцан зохион байгуулна.

2.2. Түвшин тогтоох үйл ажиллагаа нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

2.2.1.Дипломат албаны ерөнхий мэдлэгийн сорилт,

2.2.2.Гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоох,

2.3. Дипломат албаны ерөнхий мэдлэгийн сорилтыг дараах сэдвүүдийн хүрээнд явуулна:

2.3.1. Монгол Улсын гадаад бодлого,

2.3.2. Монгол Улсын Дипломат албаны холбогдолтой хууль тогтоомж,

2.3.3. Олон улсын эрх зүй,

2.3.4. Олон улсын эдийн засгийн харилцааны асуудлууд,

2.3.5. Консулын харилцаа,

2.3.6. Дипломат ёслол.

2.4. Гадаад хэлний мэдлэгийн түвшинг дараах хэлбэрээр тогтооно:

2.4.1. Гадаад хэлээр гадаад харилцаа, дипломат албаны холбоотой оноосон сэдвээр 500 үгтэй зохион бичлэг бичнэ.

2.4.2. Олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төрийн харилцаатай холбоотой сэдвээр 200 орчим үгтэй хоёр өөр материалыг монгол хэлнээс тухайн гадаад хэл рүү, тухайн гадаад хэлнээс монгол хэл рүү хөрвүүлнэ.

2.4.3. Улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй, банк, санхүүгийн холбоотой тогтсон хэллэг бүхий сэдвээр тухайн гадаад хэл дээр сонсголын дасгал ажиллана.

2.4.4. Улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй, банк, санхүүгийн холбоотой чиглэлээр тодорхой сэдвээр тухайн гадаад хэл дээр 5-10 минутын харилцан ярилцлага хийнэ.

2.5. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний түвшин тогтоох шалгалтанд орж өндөр үнэлгээ авсан, энэ тухай гэрчлэх баримт бичиг бүхий нэр дэвшигч нь энэ журмын 2.4-ийн 2.4.1, 2.4.3-д зааснаас чөлөөлөгдөнө. Ийнхүү чөлөөлөгдсөн нэр дэвшигчийн авсан нийт оноон дээр 30 оноо шууд нэмэгдэнэ.

### **Гурав. Түвшин тогтоох үйл ажиллагааны дүнг гаргах**

3.1. Дипломат албаны ерөнхий мэдлэгийн сорилын материал нь 30 асуулттай байх бөгөөд зөв хариулт бүрийг 1 оноогоор үнэлнэ.

3.2. Гадаад хэлний түвшин тогтоолт нь нийт 60 оноотой байна.

3.3. Дипломат албаны ерөнхий мэдлэгийн болон гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоох үйл ажиллагааны дүнг гаргахын өмнө нэр дэвшигчтэй комиссоос ярилцлага хийх бөгөөд ярилцлагын дүнд 10 хүртэл оноо нэмж өгнө.

3.4. Дипломат албаны ерөнхий мэдлэгийн болон гадаад хэлний түвшин тогтоох үйл ажиллагаа нь нийт 100 оноотой байх бөгөөд нийлбэр дүнгээр 70 буюу түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газарт томилогдон ажиллах болзол шалгуурыг хангасан гэж үзнэ.

---oOo---